



Цагаан Лянхуа Цэцгийн Судар

Номын багш хэмээх 10-р бүлэг

Шагжамүни нь Эмийн хаан нэртэй бодисадва болон бусад наян мянган бодисадва нарт хандаж ийнхүү хэлэв:

“Лянхуа Цэцгийн Сударын нэгэн хэсгийг сонсоод, ганц агшим ч гэсэн талархалтай гэж бодсон хүн бүрт гэгээрлийг олох баталгаа олгоё. Мөн намайг энэ хорвоогоос явсаны дараа ч Лянхуа Цэцгийн Сударыг сонсоод чин сэтгэлээсээ баярлан талархах хүн бүрт Буддын гэгээрэлд хүрэх баталгаа олгож өгье.

Ямар хүн ирээдүйн ертөнцөд Будда болохыг зааж өгье. Энэ бол Хүлээн авах, Унших, Давтах, Тайлбарлах, Бичих сэтгэлээс хамаарна. Өөрөөр хэлбэл, Лянхуа Цэцгийн сударын сургаалыг хүлээн авч итгэж, байнга давтан сурч, сурсан сургаалаа дахин дахин давтан дуулж, хүмүүст тайлбарлаж, бичиж хуулж сургаалыг ертөнцөөр тарааж чаддаг хүн нь Будда болно. Тийм хүн бол Буддыг төлөөлж энэ ертөнцөд төрдөг юм. Мөн тэр хүн бол өнгөрсөн ертөнцөдөө тоолж барашгүй олон будда нарт мөргөл үйлдэж, олон ардыг аврахсан гэсэн хүслээ гаргасан хүн юм. Мөн түүгээр сэтгэл нь ханахгүй учраас одоогийн ертөнцөд зовж буй ардыг аврах гэсэн нигүүлсэхүйн сэтгэлээс үүдэж, хүний ертөнцөд төрсөн юм. Хүмүүс Буддад ханддаг шиг тэр хүнд ч талархах ёстой. Хэрэв хэн нэгэн хүн удаан хугацаагаар Буддаг муулж гоочилдог байсан бол тэр хүний нүгэл нь хөнгөнд тооцогдоно. Харин хэн нэг нь Лянхуа Цэцгийн Сударын сургаалыг уншиж буй хүнийг муучилж гоочилбол тэр хүний нүгэл нь маш хүндэд тооцогдох болно. Яагаад гэвэл Лянхуа Цэцгийн Сударыг уншиж мөргөдөг хүн бол маш хүнлэг юм”.

Түүнчлэн тэрээр дараа нь Лянхуа Цэцгийн Сударын сургаалыг үйлдэх сэтгэлийн тухай тайлбарласан билээ:

“Миний сургаал бол тоолж барашгүй бөгөөд бүх сургаалын дотор Цагаан Лянхуа Цэцгийн Сударын

сургаал нь ойлгоход хамгийн бэрх сургаал юм. Тийм ч учраас, хүнд ад үзэгдэх, атаа жетөөний бай болох магадлага ч өндөр. Гэсэн ч тэсэж, даван туулаарай. Бурхан түүнд “хувцасаа” өмсүүлж хамгаалах болно” гэж амлажээ.

Мөн: “Хээр газрыг уг мухраар нь ухаж мэдэхийг хичээсэн нь” гэсэн үлгэр жишээний ярианы дагуу хээрд худаг ухахтай адил Лянхуа Цэцгийн Сударын сургаалыг дагасан хүн бууж ухралгүй, нэгэн зарчимынхаа дагуу явах хэрэгтэй юм” гэж хэлэв.

Шагжамүниг энэ хорвоогоос явсаны дараа Цагаан Лянхуа Цэцгийн Сударын сургаалыг айлдахдаа “Бурханы оронд орж, Бурханы орхимжийг нөмөрч, Бурханы жавдан дээр сууж сургаалаа айлд. Бурханы орон гэдэг нь Агуу Их Нигүүлсэхүйн Сэтгэл, Бурханы орхимж гэдэг нь Зөөлөн Тэвчээртэй Сэтгэл, Бурханы жавд гэдэг нь хоосон сэтгэл буюу бүхнийг эрх тэгш авч үздэг үндсэн үнэн юм. Эдгээрийг сэтгэлдээ шингээж бодисадва нарт ба ард түмэнд сургаалаа айлд” гэж заажээ.

“Энэхүү сургаалыг айлдах үед ямар нэгэн саад бэрхшээл гарвал Буддаг санаж тэсээрэй. Намайг энэ хорвоогоос явсаны дараа сургаалыг зөв тайлбарлаж ярьж чаддаг хүн гарч ирвэл би түүнд сүсэгтний дүрд хувирсан хүмүүсийг илгээж, олон ард цуглуулж, мөргөл үйлдүүлэн сургаалыг нь сонсуулах болно. Үүнд саад тохиолдвол би биеэ хувирган үзүүлж түүнийг хамгаалах болно. Тэр хүнээс сургаал сонссон хүн нь бодисадва болж, Ганга голын элсийн тоотой адил олон будда нартай учрах болно” гэж хэлжээ.



Мөнхийн Амь насыг амьдрах нь

Зэн шашны содон үзэл бодлоороо алдартай Иккюү зэн-багш дээр урт удаан наслах адис авахаар нэгэн хөгшин ирсэн гэнэ. Иккюү зэн-багш тэр хөгшинд: “Бид хэзээ ч үхэхгүй шүү дээ” гэж хэлсэн байна. Түүнчлэн: “Шагжамүнигийн сургаалын дагуу бол бидний махан бие өтлөн үхсэн ч, хүн бүр мөнхийн амьдралыг туулж чадах юм. Сургаалыг хүлээн авч, сургаалын замаар амьдарч, Мөнхийн Язгуурын Үнэнтэй нэгэн бие болж орхивол үхэл нь асуудал биш болно” гэж хэлсэн байна.

Тэр хөгшин нь даруйд зэн-багшийн шавь болж, үлдсэн насаа аз жаргалтай өнгөрүүлсэн байна. Хүмүүс бид уг үндсэндээ зайлшгүй бөгөөд хязгааргүй мөнх ертөнцтэй нэгэн бие гэдгээ ухамсарлаж амьдрах нь чухал гэдгийг зэн-багш бид нарт заасан байна.

Мөн Сэйтоку хун тайж нь: “Хорвоохийсвэр, Будда-цорын ганц Үнэн” гэж хэлдэг байв. Энэ нь ямагт өөрчлөгдөн хувирч, төөрөгдөж байдаг хүний хорвоо бол түр зуурын зүйл бөгөөд гагцхүү цорын ганц үнэн зүйл бол Буддын ертөнц юм гэсэн утгатай.

Ийнхүүгээр бодоход бидний одоогийн ертөнцийн амьдрал нь ямар ч утгагүй мэт санагдаж магадгүй. Гэвч тийм биш юм. Харин ч Мөнхийн Амьдрал гэдэг нь юу вэ, Язгуурын Үнэний Ертөнцтэй нэгэн бие болно гэдэг нь ямар зүйл вэ? гэдгийг өөрийн бие махбодиор насан туршдаа суралцаж явах нь бидний амьдралын утга учир болов уу. Хүний ертөнцөд шашин байдаг учир нь үүнд оршдог болов уу.



Бүх хүмүүсийн амгалан тайвныг хүсэн ерөөе

Та бүхэн 4 сарын 8-ны өдөр бол Шагжамүнигийн Төрсөн Амин Өдөр гэдгийг сайн мэдэх байх. Шагжамүнийг бид “Газар дэлхий,огторгуйн цорын ганц Багш” гэж нэрлэдэг бөгөөд Шагжамүни нь “Төөрөгдөлөөр дүүрсэн ертөнцөд зовж шаналж буй ард түмэнд би амгалан тайвныг олгож өгнө” гэж хэлсэн билээ.

“Бүгд зовдог” гэж хэлэгддэг энэхүү ертөнц нь зовж шаналсан хүнээр дүүрэн билээ. Гунигтай ба зовлонтой явдалтай учирдаггүй хүн гэж байдаггүй. Тиймээс ч Шагжамүни нь бид нарт:” Амьдрал бол санасны дагуу бүтдэг зүйл биш. Түүнийг заавал санааныхаа дагуу болгоё гэсэн таны сэтгэл чинь бүх зовлон шаналгааны уг үндэс болдог юм. Язгуурын Үнэнийг гэгээрэн ухаарвал зовлонгоос ангижирч,эрх чөлөөтэй амьдрах болно” гэж заасан билээ.

Энэхүү сургаалын үг нь зарим хүнд хүйтэн санагдаж байсан байж магадгүй. Гэвч энэ нь уг үндсэндээ аврал болж, олон хүн жинхэнэ амгалан тайвныг олсон байна.Өөрөөр хэлбэл, бүх хүмүүст амгалан тайван олгох нь Шагжамүнигийн амьдралын утга учир байсан юм.

Бид ч Шагжамүнитэй адил нэгэн л

зорилготой: аль болох олон хүнд Язгуурын үнэнийг дамжуулж, амгалан тайвныг олгох явдал юм. Хүн хичнээн том бэрхшээл зовлонтой учирсан ч Язгуурын Үнэнийг гэгээрвэл урагшаа тэмүүлж чадна.

Зовлонг сайтар ажиглан харж, түүн дотор байгаа Үнэнийг олж ухаарах—энэ нь хэцүү боловч хүн дандаа бусдын хүчээр амьдрахгүй. Өөрийн хүчээр Язгуурын Үнэнийг олж сурах хэрэгтэй.

Дахин давтан хэлэхэд үнэн гэдэг нь зарим үед маш хатуу байдаг зүйл юм. Нэг үе сэтгэл шархлаж зовж ч магадгүй. Гэсэн ч үнэхээр Язгуурын Үнэнтэй учирсан үед “маш чухал юм зааж өгсөнд баярлалаа, гялайлаа” гэж талархах болно.

Үнэнийг гэгээрнэ гэдэг бол жинхэнэ бодит байдлын утга учрыг мэдэж ойлгоно гэсэн үг билээ. Ингэснээр бид амьдралын гайхамшигт талыг мэдэх болно: хүний бие махбоди нь хязгаартай боловч бид ийнхүү амьдарч байгаагийнхаа утга учрыг мэдэрч гэгээрнэ.

“Косэй”2012 оны4 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч
Нивано Коошо

Мэндчилгээ

Хүүхэд том хүнийг дуурайх маш дуртай байдаг.

Хүүхдийнхээ хэрэглэж буй үг хэллэг, зан хөдөлгөөнийг нь сайвтар ажиглахад өөрөө хүүхэдтэйгээ өдөр тутам хэрхэн харьцаж байдаг нь илт харагддаг учраас заримдаа бүр ичих шиг болдог. “Битгий тэгж ярьж бай” гэж хүүхдээ засах гэтэл хажууд байсан нөхөр маань “Яг ээж шигээ ярих юм аа” гэхэд нь хэлэх үг ч олддоггүй юм.

Хүү маань цэцэрлэгт явдаг байсан үед би түүнийг өглөө бүр машинаар хүргэж өгдөг байв. Ариун Их Ордоны хажуугаар өнгөрөхдөө бид хоёр заавал “Даймоку”-г гурван удаа хэлж мөргөдөг юм. Би өрөөсөн гараа л гаргаж, хүү маань хоёр гарныхаа алгаа хавсруулан мөргөдөг байв. Гэтэл нэг удаа хүү маань мөргөх үедээ байн байн намайг харах тул яасан бол гээд харахад тэр маань бас ганц алгаараа мөргөж байсан юм. Тэвчилгүй инээд хүрсэн шүү.

Мөн нэгэн үдэш оройн уншлагынхаа сүүлчийн ёсыг гүйцэтгээд мөргөөд босох гэтэл хүүгийн маань тохой нь хажуугаас тулаад ирэв. Хүү маань үргэлж миний хажууд над шиг өвдгөн дээрээ гараа тавьчихаад суудаг байсан бол энэ удаад хоёр тохойгоо хоёр тийш нь нугалан толгойгоо бөхийж мөргөж байв. “Миний хүү ямар мундаг юм бэ” гэж магтахад тэр шууд үсрэн босож “Ямар-ямар гэдэг баатар”-ын дүр эсгэж зогсов.

Хүүд маань нэгэн бэрхшээл байсан юм. Тэр нь өглөө бүр цэцэрлэгийнхээ эрхлэгч багштайгаа мэндлэх явдал байлаа. Цэцэрлэгт дөнгөж орсон үедээ бол эхлээд өглөө бүр уйлдаг байсан бол яваандаа дасаад ирэхлээрээ ичсэндээ болж багштайгаа мэндчилж чаддаггүй байв. Шахаж шаардаад яахав гэж бодоод юуны би өөрөө жишээ үзүүлж, өглөө бүр багш нартай нь хичээнгүйлэн



Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.

мэндчилдэг байлаа. Гэтэл ерөөс байдал өөрчлөгдсөнгүй. Хэсэг хугацааны дараа би ч тэсэлгүй “Алив, багштайгаа мэндэл” гэж толгойгыг нь бөхийлгөсөн ч хүү маань намайг дуурайх дур нь ийм үед л алга болдог бололтой байв.

Ийнхүү бараг найдлага тасарсан байсан нэгэн өглөөний явдал. Тэр өглөө ч хүү маань эрхлэгч багшийн нүдийг ч харалгүй найзтайгаа тоглонгоороо мэндэлсэн болоод цэцэрлэг үрүүгээ гүйгээд явав. Гэвч тэр агшинд би хүүгийнхээ сэтгэлийг олж харж чадсан юм. Тэр маань багштайгаа сайн мэндэлмээр байгаа боловч боломж олдохгүй байгаа мэт санагдсан юм. Яг тэр өдрийн орой нь эмээ нь хүүгээс: “Чи бол манай гэрийн хамгийн бяцхан хүн боловч цэцэрлэг дээрээ багш нартайгаа сайн мэндчилж сурав уу?” гэж асуухад хүү маань дургүй юмаа санасан мэт царайлав.

“Миний хүү цэцэрлэг дээрээ ёстой сайн мэндчилдэг шүү. Ээж нь маш их баяртай байна” гэж намайг хэлэхэд хүү маань над уруу гайхан харав. “Өө тийм үү, миний хүү тэгвэл эмээдээ бас үзүүлээрэй” гэж эмээ нь хэлэхэд хүү маань баярлан “За, дараа би танд үзүүлнээ” гэж хариулсан билээ.

Гакүрин сургуульд сурсан 2 жил ба цаашдын зорилго

Гакүрин сургууль, Гадаад ледир бэлдэх
курсын 18-р төгсөлт

Вантила Жаяасэкара

Энэхүү илтгэл нь 2012 оны 2 сарын 27-нд “Төгсөгчдийн бие даалтын ажлын хамгаалалт” дээр тавигдав.

Гакүрин сургуулийн Гадаад ледир бэлдэх курст сурсан 2 жил амьдралын минь үнэт эрдэнэ байлаа. Энэ 2 жилийн хугацаанд баяр хөөр, уйтгар гуниг, хатуу чанга зүйл олон тохиолдсон.

Би нэг эгчтэй ба эгч маань үргэлж гэрийн ажлыг хийж, харин ба гэрийн ажилд туслахгүй эрхэлж өссөн. Ганцаараа юу ч хийж чадахгүй, чадах байсан ч хийхийг хүсэхгүй, хийе гэсэн зүйлээ л хийж ирсэн. Үргэлж аав, ээждээ эрхэлж, зовлох юмгүй сайхан амьдарч ирсэн.

Ямар ч санаа зовж, гунихрах зүйлгүй байсан амар амгалан амьдрал маань 2010 онд Гакүрин сургуульд орсноор эсрэгээр өөрчлөгдсөн юм.

Огт мэдэхгүй, ярьж чадахгүй Япон хэлтэй тулгарч, дээр нь ангидаа ганцаархнаа эмэгтэй гээд, тийм нөхцөлд хичээх хэрэгтэй болсон юм. Гэртээ байхдаа хийдэггүй байсан ажил болох эрт босох, хоол хийх зэргийн хэцүүг ойлгож ирэв. Өнөөг хүртэл сайхан байсан амьдрал эрс өөрчлөгдсөнөөр эцэг эх, эгчдээ талархах сэтгэл төрсөн юм. Гакүрин сургуульд ороод хамгийн түрүүнд сурсан зүйл бол өөрийнхөө зүйлийг өөрөө хийх байлаа. Япон хэлний хичээл, ханзанд дургүй миний хувьд 2 жил энэ сургуульд сурч чадах болов уу гэсэн зовиур байсан. Япон хэлний түвшин тогтоох шалгалтанд үргэлж санаа зовж “би үргэлж л юу ч чадахгүй юм да,

хэрэв шалгалтандаа тэнцэхгүй бол яах вэ” хэмээн байнга л боддог байв. Ангийхан бүгдээрээ толгой сайтай болохоор хичээлээ ойлгоно, би эмэгтэй болохоор чадахгүй гэх зэргээр өөрийгөө ангийнхантайгаа харьцуулж, улмаар ангийнхаа хүүхдүүдтэй муудалцаж, багш нарынхаа сэтгэлийг зовоож байсан.

Би Японд ирээд удаагүй байхдаа бугуйгаа гэмтээсэн юм. Баруун бугуйгаа гэмтээгээд юу ч хийж чадахгүй болсон тэр үед ангийхан маань миний өрөөсөн гар болж тусалсан. Тэр үеэс ангийнхаа гурван хүүхдэд итгэдэг болсон юм.

Түүнээс гадна сэтгэл санааны хувьд ч сул дорой бөгөөд үргэлж л чадахгүй гээд сэтгэлээр унадаг байсан намайг багш нар маань чанга хатуу сургаж өгсөн билээ. 1-р ангид байхдаа багш нарынхаа сайхан сэтгэлийг ойлгоогүй боловч 2-р ангид ороод намайг хөгжүүлэхийн тулд хатуу хандаж байсан багш нарынхаа сэтгэлийг ойлгосон. Багш нар маань миний эрх дураараа занг хараад “Вантэра, чи хүүхэд биш шүү дээ, том болооч!” гэж хатуу хэлж байсан. Түүний ачаар би одоо өөрийнхөө асуудлыг өөрөө шийдэж, өөрийнхөө хөл дээр босож чаддаг боллоо. Хатуу чанга мөн эелдэг зөөлөн хандаж байсан багш нартаа талархлаа илэрхийлье.

Би өнгөрсөн жилийн 5 сард нийгэмлэгийн дадлагад явсан. Тэр үед би зөвхөн өөрийгөө л бодож, “нийгэмлэг дээр очмооргүй байна”,

“айгаад байна, сургууль руугаа буцъя” гэх зэргээр хэлж байсан. Яагаад гэвэл, цунами болсны дараа нийгэмлэг цахилгаан хүчээ хэмнэж гэрлээ унтрааж байсны улмаас нийгэмлэг харанхуй байсан ба нийгэмлэгийн эргэн тойронд булш, оршуулгын газар байсан болохоор би их айж байсан. Нийгэмлэгийн орчин тойрныг хараад, ногооны талбайгаар хүрээлэгдсэн, орой болохоор тас харанхуй болчихдог аавынхаа ээжийн гэрийг санах. Шриланкад байхдаа эмээгийнх рүүгээ явахад айгаад хааяа л эмээтэйгээ уулздаг байсан юм. Тэр үед багш дадлагын явцыг шалгаж, надтай ярилцахаар нийгэмлэг дээр ирсэн юм. Тэгээд “эмээ чинь аавыг чинь төрүүлээгүй байсан бол чи ч бас төрөхгүй байх байсан шүү дээ” гэж эмээгээ хайрлахын чухлыг ухааруулсан. Тэр үеийг хүртэл би эмээ рүүгээ утсаар ч ярихгүй, захиа ч бичдэггүй байсан боловч дадлагаа дуусаад сургууль руугаа буцсаны дараа эмээ рүүгээ утсаар ярьж чадсан. Утсаар юу гэж ярьдаг юм билээ, намайг таних болов уу гэж бодонгоо утсаар залгав. Эмээ миний дууг сонсоод ихэд баярлаж, “утсаар ярьсанд баярлалаа” гэж хэлсэн. Нийгэмлэгийн тэргүүн болон багшийнхаа ачаар би эмээдээ талархдаг болж, утсаар ярьж чадсан билээ.

2 дахь удаагийн дадлагын тухайд “нэг хүн гишүүнээр элсүүлнэ” гэсэн зорилго тавьж явсан боловч гишүүн элсүүлж чадахгүй сандарч байлаа. Тэр үед нийгэмлэгийн залуу гишүүдтэй Их ариун танхимд мөргөхөөр явсан ба хоза дээр гишүүн элсүүлж чадахгүй шаналж байгаагаа ярих. Гэтэл хоза удирдагч “нийгэмлэгт элсэх, элсэхгүй нь хамаагүй, гол нь тэр хүн чамтай уулзсандаа баяртай байх нь чухал” гэж зөвлөв. Үүгээр дамжуулан “энэ хүнийг гишүүн болгомоор байна” гэсэн сэтгэл маань “энэ хүнийг баярлуулъя” гэсэн сэтгэл болж хувирав. Мөн хүний яриаг сайн сонсож, өөрөө ч ярьж, хүмүүстэй хөгжилтэй яриа өрнүүлэхийг хичээдэг болов. Улмаар нийгэмлэгийн ахмад гишүүдийн

тусламжтайгаар нэг хүн гишүүн элсүүлж чадсан юм. Нийгэмлэгийн тэргүүн “Вантэра одоо гишүүн хариуцах болсон юм чинь нийгэмлэгийн гишүүдээс тусламж, дэмжлэг авангаа гишүүнээ харж хандаж байгаарай” гэж хэлсэн ба эндээс гишүүн элсүүлээд л дуусах биш, элсүүлсний дараагийн процесс нь илүү чухал болохыг ойлгож, үүрэг хариуцлагыг мэдэрсэн.

Нийгэмлэгийн дадлагын үеэр өөр нэг сайхан учирал байсан. Тэр бол 30 настай нэгэн эмэгтэйтэй учирсан явдал байлаа. Тэр эмэгтэй өвчний улмаас гэрээсээ бараг гардаггүй байв. Мөн бурхан гэх мэт хийсвэр зүйлд итгэдэггүй хүн байв. Би тэр эмэгтэйтэй “Үүсгэн байгуулагчийн сургаалтай учраасай, нийгэмлэг дээр ирээсэй” гэж хүсэж байлаа. Нэг удаа тэр эмэгтэйтэй нийгэмлэг дээр очно гэж хэлсэн боловч, утсаар “Эрч хүч, зориг хүрэхгүй байна. Маргааш очиж чадахгүй нь ээ, уучлаарай” гэж хэлээд ирж чадахгүй болчихов.



Төгсөгчдийн бие даалтын ажлаа хамгаалах сименарын байдал

Би үүнийг сонсоод итгэж чадахгүй, юу ч болсон хамаагүй ирүүлмээр байна гэсэн хувиа хичээсэн бодлоор хандаж байсан юм. Энэ талаар тэргүүнтэй ярилцтал, тэргүүн “Вантэра, гадаа ч гарахыг хүсэхгүй, найз нөхөд ч бараг байхгүй тэр эмэгтэй нийгэмлэг дээр очно гэж хэлсэн нь төдийд л баярламаар зүйл шүү дээ” гэж хэлсэн юм. Өмнө нь би өөрөө ч бас залуу гишүүд уулзъя гэхэд нь явмааргүй санагдаад, утсаар ярих зүрх хүрэхгүй мессэж бичиж татгалзаж байсан удаа бий. Харин тэр эмэгтэй бол зориг гаргаж над руу утсаар ярьсан юм. Тэгээд би тэр эмэгтэй рүү утсаар ярьж, “Зориг гаргаж над руу ярьсанд баярлалаа. Таньтай уулзсандаа би их баяртай байдаг шүү” гэж дамжуулав. Эцэст нь тэр эмэгтэй “Би чамаас эрч хүч авсан шүү” гэж хэлээд надтай уулзахаар нийгэмлэг дээр ирсэн юм. Би энэ учралыг нандигнаж явдаг ба үүгээр дамжуулж 2 зүйлийг ойлгосон.

Нэгдүгээрт хүнд өөрийнхөө сэтгэлийг тодохрой дамжуулах явдал. Хоёрдугаарт, харилцаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгож, санаа тавих явдал болно.

Би нутаг буцаад сургаалыг түгээж, хүмүүсийг аз жаргалтай болгохыг зорин хичээе гэж бодож байна. Үүний тулд Гакүрин болон нийгэмлэгийн дадлагаар сурсан “Хүний яриаг сайн сонсох”, “Бодсон зүйлээ тэр дор нь хэлэх”, “Өөрийнхөө туршлагыг бусадтай хуваалцах” гэсэн үйлийг хэрэгжүүлнэ.

Эцэст нь 2 жилийн турш тусалж дэмжиж байсан Гакүрин сургууийн багш нар болон сургуулийн анд нөхөддөө талархлаа илэрхийлж, илтгэлээ төгсгөө.

Та бүхэнд баярлалаа.



Эхний эгнээний баруун талаасаа 4 дахь нь Вантэра болно





Ачийг хариулах буяны үйл

Галт тэргэнд нялх хүүхэд тэвэрсэн эмэгтэй зогсож байвал суудал тавьж өгнө, хөгшин хүн дэргэд зогсож байвал мөн суудал тавьж өгнө.....хүн бүр урьд өмнө ийнхүүгээр хүнд тусалж, өөрөө ч хөгшрөөд ирэхлээрээ хүний ач тусыг үздэг билээ. Бүх зүйлс бие биентэйгээ солилцон харилцаж, авран авралдаж байдаг хорвоо юм.

Бидний одоогийн амьдрал эд зүйлээр маш баялаг байгаа боловч дэлхийд өлсгөлөн, ядуурлаас болж олон хүн нулимсаа асгаруулж байгаа нь үнэн юм. Япончууд бид ч дайны дараа хүнс, бараагаар дутагдаж, гадаадаас тусламж авч амь гарч байснаа мартаж болохгүй.

Тухайн цаг үед Америк нь өөрийгөө “Дэлхийн цагдаа” гэж ухамсарлаж, бусад орнуудын аюулгүйн байдлыг хариуцан, тусламж үзүүлэн ирсэн боловч эдгээр хүчин чармайлт нь тус орнуудад дүгнэлт муутай байсан билээ. Ёс зүйгээ хэт хүчээр тулгасанаас болсон байж магадгүй юм.

Тусламж өгөх, буян үйлдэх гэдэг нь баян нь ядуугаа өрөвдсөндөө өгдөг гэсэн ойлголт бол буруу юм.

Хоол хүнсгүй өлсөж байгаа, эсвэл хүч тамиргүй өтөлсөн хөгшин учраас би тусална гэсэн үүднээс биш харин өөрт оногдсон аз жаргалтай амьдралынхаа ачийг хариулж буяны үйл хийж байгаа юм гэж бодох нь зүйтэй юм.



From *Kaisozuikan* 5 (Kosei Publishing Co.), pp.230-231

Таны инээд дармаг түгээнэ

Column

Тайван улсын өмнөд хэсэгт орших Тайнан нийгэмлэгийн тэргүүн Жуан гуай 30 жилийн өмнө нэгэн Япон хүн ажлынхаа ариун цэврийн өрөөг өдөр бүр цэвэрлэж байхыг хараад маш их сэтгэл хөдлөсөн гэдэг. Тэр хүн Оодатэ нийгэмлэгийн гишүүн байсан ба улмаар Жуан гуай Рисшо Косей Кайд гишүүнээр элссэнээр Тайнан нийгэмлэгийн анхны гишүүн төрөв.

Ганц хүний чин сэтгэлийн үйл далайг гатлан Тайван улсад хүрч, маш олон хүмүүст аз жаргалыг түгээжээ. Хүний амьдрал гэдэг хязгаартай. Тэрхүү богинохон амьдралынхаа хугацаанд өдөр бүр хэрэгжүүлж ирсэн үйл хэзээ нэгэн цагт, хаа нэгтээ, хэн нэгэнд тус хүргэж байна гээд бодоод үзвэл, эрч хүч, баяр хөөрийг мэдрэх болов уу. Таны инээд аль хэдийн мөнхийн орших жинхэнэ үнэн, дармаг түгээж байгаа билээ.

Жуан тэргүүн өнгөрсөн сард насан өөд боллоо. Жуан тэргүүнд чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн зэрэгцээгээр ирэх төрөлдөө амар амгалан байхыг хүсэн ерөөе.

Олон улсад сургааль түгээх төвийн дарга
Шооко Мизутани

Special Topics

Зүүн Японд болсон газар хөдлөлтөөс хойш 1 жил өнгөрөөд байна. 3 сарын 11-нд Их ариун танхимд Газар хөдлөлтөд нирвэгдэгсдийн хойтын буянд зориулж, мөн гамшигт өртсөн бүсийн цаашдын хөгжлийг билэгдэж ном хурсан ба бусад газар нутаг бүрээс мөн адил залбирсан билээ. Энэ 1 жилийн хугацаанд дэлхийн өнцөг булан бүрээс маш их чин сэтгэлийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн явдалд сэтгэлийн гүнээс талархлаа илэрхийлье. Хойшид ч газар хөдлөлтөд өртсөн бүсийн хөгжлийн төлөө нэгэн сэтгэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болно. Ингээд дэлхийн өнцөг булангаас ирсэн гишүүдийн мессэжээ танилцуулж байна.



Солонгос нийгэмлэг



Хавай нийгэмлэг

Зүүн Японд болсон газар хөдлөлтөөс хойш 1 жил өнгөрлөө.

Газар хөдлөлөөр өөд бологсдын сүнс уй гашуу, зовлон шаналалаа энэ ертөнцөд орхин, бурхны хамгаалалд орж, бурханлаг чанараа нээж, зовлонгоос ангижиран амар амгалан байх болтугай хэмээн чин сэтгэлээсээ залбиран мөргье.

Таипэй нийгэмлэг

Япон дахь нийгэмлэгийн төв дээр хойтын буянд зориулж ном хурах болгонд Тайнан нийгэмлэгийн гишүүд бид ч хамтдаа ном хурж байдаг шүү.

Тайнан нийгэмлэг



Шриланк нийгэмлэг



Бангкок нийгэмлэг, хандив цуглуулах үйл ажиллагаа

Бид бүхэн та бүгдийг үргэлж бодож үргэлж хамт байдаг шүү. Бидний сэтгэлээ чанга барьж, амар амгалан, энэрэнгүй байх юм бол давж туулж чадахгүй зүйл гэж байхгүй.

Бангладеш нийгэмлэг

special thanks



Оклахама нийгэмлэг

Бид та бүхэнтэй нэг сэтгэлтэй байгаа шүү.

Лос Анжелэс нийгэмлэг

Том хэмжээний байгалийн гамшигийг даван туулахад маш их сэтгэлийн тэнхээ хэрэгтэй. Сэтгэлээ сайтар чангалж, сургаалыг түшиг тулгуураа болгон хүнд хэцүү байдлыг давж гараарай.

Хойд Америкын олон улсын төв нийгэмлэг

Дэмжлэг туслалцаа үзүүлсэн гадаадын гишүүд та бүхэндээ баярлалаа.



Нью Йорк нийгэмлэг, Лаёнс клубээс зохион байгуулсан хандив цуглуулах үйл ажиллагаанд оролцов



Монгол нийгэмлэг, хандив цуглуулах үйл ажиллагааны дараа

Энэ 1 жилийн хугацаанд гамшигт өртсөн бүсийн хөгжлийн төлөө зориулсан та бүхний энэрэнгүй сэтгэл бол Цагаан Лянхуа судар, Үүсгэн байгуулагчийн сургаалын мөн чанар, түүнчлэн бодисадвагийн үйл тэр чигээрээ юм. Та бүхний дүр төрх гадаадын гишүүд бидний сэтгэлийг хөдөлгөж, зоригжуулж, бидэнд үлгэр дуурайл болсон. Та бүхний цаашдын хичээл зүтгэл гамшигт өртсөн бүс нутгийг сэргээж, хүсэл мөрөөдлийг өгөх болтугай .


Европ нийгэмлэг

Уйтгар гуниг, зовлон гэдэг мартаход хэцүү ч цаг хугацаа зөөлрүүлж өгнө. Сэтгэл үймэрсэн үедээ О-даимокүг дахин дахин уншаарай. Ингэх юм бол сэтгэл тайвширна. Та бүхний аз жаргалын төлөө бид чин сэтгэлээсээ залбирч байна.

Хонг Конг нийгэмлэг

Энх тайвны төлөө бурхан багш, үүсгэн байгуулагчийн сургаалыг түгээж, сэтгэлээ нэгтгэн хамтдаа аз жаргалтай болцгооё.

Сахалин нийгэмлэг



Колкат нийгэмлэг, өөд бологсдын хойтын буянд зориулсан номын хурал

SHAN ZAI

Buddha's Wisdom Changes Your Life

Санал хүсэлт


“Shanzai” сэтгүүл нь та бүхний санал хүсэлтийг хүлээн авч байна.

Материал нийтлүүлэх, Буддизмын тухай мэдмээр байгаа зүйл, Ямар нэгэн асуудал зэргийн талаарх зөвөлгөө болон сэтгүүлийн талаарх санал хүсэлтийг бид баяртайгаар хүлээн авах болно.

Холбоо барих хаяг энэ хуудасны төгсгөлд хэвлэгдсэн байгаа. Та бүхнийг олон сайхан санал, хүсэлт илгээнэ гэдэгт найдаж байна.

Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо бодон Хамтран үндэслэгч Наганүма Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашины байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашины бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар бариц, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Volume 79 (April 2012)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, Japan. PO Box 166-8537 TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : shanzai@kosei-kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна. Зарим дугаар нь бусад орны хэл дээр хэвлэгдэх ториолдол байдаг.

※Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.

※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2012

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.rkina.org/tampabay>

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 N Race St., Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Other Groups****Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China